

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-6

- 
1. *Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу тодорхой асуудлын хүрээнд дахин хэлэлцэх/*
- 4-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 01-ний өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Заяабал;

Чөлөөтэй: Г.Тэмүүлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батцэцэг, Х.Болормаа, Ж.Ганбаатар, З.Мэндсайхан.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу тодорхой асуудлын хүрээнд дахин хэлэлцэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн төслийн талаар танилцуулав.

**Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал**

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатар, Дав.Цогтбаатар, П.Сайнзориг нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 16.1.1.7 дахь хэсгийн Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, 4 эгнээ, 113.1 км гүүрэн байгууламж, 185,6 урт/метр, /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, санхүүжих дүн 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 39,951.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлэх. Үүнд:

1.Төслийн 2 дугаар хавсралтын 25.3.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 15,275.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.Дүүргийн Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг 12,801.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,120.4 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

3.Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 4,452.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,780.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

4.Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,320.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,928.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

5.Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

6.Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

7.Дүүргийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2013-2026 он, төсөвт өртөг 44,552.4 сая төгрөг, санхүүжих дүн 15,000.0 төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

8.Улсын ерөнхий прокурорын урсгал зардлыг 1,182.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд: 16  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 12 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 23 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр,  
Баасан гараг Төрийн ордон  
“Жанжсин Д.Сүхбаатар” танхим,  
14 цаг 11 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Даваасүрэн:** Байнгын хорооныхоо хурлаа эхэлье. Байнгын хороонд ирвэл зохих 25 гишүүнээс 15 бүртгэгдсэн 60 хувийн ирцтэй байгаа учраас хуралдааны ирц хангалттай байна. Хуралдаанд хэлэлцэх асуудлыг та бүхэн мэдэж байгаа.

Сая 2024 оны 10 сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдааны үеэр Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах, үргэлжлүүлэн хэлэлцэх шаардлагатай гэж буцаасан байгаа. Энэ асуудлыг би та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах чиглэлийн дагуу. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу. Нэг л асуудал байна. Алга байна.

Ажлын хэсэг. Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны газрын дарга М.Санжаадорж, Б.Тэлмүүн, Г.Золбоо, З.Энхболд, Ж.Дэлгэржаргал, Сангийн яамны хэлтсийн дарга Л.Гантогтох, Б.Амарбаясгалан, Солонгын Тулга, Б.Ганзориг, Б.Отгонцэцэг гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзэн Төсвийн байнгын хороонд буцаасан байгаа. Ингээд Дэгийн тухай хуулийн энэ заалтын дагуу төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд хэлэлцэж эхэлье.

Хууль зүйн байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал дээр буцсан. Та бүхэн мэдэж байгаа. Хууль зүйн байнгын хорооноос ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан байгаа. Та бүхэн танилцсан байгаа байх. Энэ гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Хууль зүйн байнгын хорооноос ирсэн саналыг та бүхэнд танилцуулъя.

Төслийн 2 дугаар хавсралтын 16.1.1.7 дахь хэсгийн Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, 4 эгнээ, 113.1 км гүүрэн байгууламж, 185,6 урт/метр, /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, санхүүжих дүн 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 39,951.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлэх. Үүнд:

1.Төслийн 2 дугаар хавсралтын 25.3.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 15,275.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.Дүүргийн Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг 12,801.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,120.4 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

3.Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 4,452.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,780.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

4.Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,320.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,928.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

5.Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

6.Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

7.Дүүргийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2013-2026 он, төсөвт өртөг 44,552.4 сая төгрөг, санхүүжих дүн 15,000.0 төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх;

8.Улсын ерөнхий прокурорын урсгал зардлыг 1,182.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Дав.Цогтбаатар, П.Сайнзориг.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хүчингүй болгоё. Нөгөө 2 дахь хэлэлцүүлгийг чинь нөгөө юу нь явчихсан. Зарчмын зөрүүтэй санал хураалт явж байгаа учраас зарчмын зөрүүтэй санал хураалт дээр тайлбарлаж л үг хэлж болно. Энэ чинь нөгөө үргэлжилж байгаа. Асуулт, үг чинь өмнө нь явчихсан байхгүй юу. Энэ чинь нөгөө санал хураалт явж байгаа шүү дээ. Санал хураалтаа үргэлжлүүлж байгаа байхгүй юу. Тийм учраас ... үгүй ээ, үгүй. Санал хураалт гэж чиглэл өгсөн. Тэр чинь санал хураалт байсан байхгүй юу. Тухайлсан асуудал нь. Энэ унасан санал байсан байхгүй юу. Тэгээд энэ унасан саналыг өөрчилж оруулж ирж байгаа юм. Энд тайлбар хийх хүн байна уу. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Үгүй ээ, үгүй. Тэгээд тайлбар хийхээр сонин болчихоод байна. Хэдүүлээ энэ чинь улс орныхоо хөгжлийг бодъё, хөгжлийн тэлэлтээ хангая, эдийн засгийн коридоруудаа нэвтрүүлэх чадамжийг нь өргөтгөө гээд ингээд зөндөө ярьсан. Тэгээд хэл амтайнхан 3, 4 жил хэдүүлээ явж байгаад Улаанбаатар, Дарханы замаа нэг юм 2 урсгалтай эгнээ өргөтгөлийг нь хийгээд, ашиглалтад оруулсан. Тэгэхээр ядаж хойд хөрштэйгөө эдийн засгийн интеграчлал гэдэг юм уу, эсвэл хойд боомтынхоо нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд Дарханаас Сүхбаатарын чиглэлийн зам хамгийн чухал зам байхгүй юу. Үүнийхээ нэвтрүүлэх чадварыг 2 дахин нэмэгдүүлье гээд 2024, 2025 оныхоо төсвийн төсөл дээр тодорхой хөрөнгө тавиад ороод ирчихсэн. Үүнээсээ юм л бол авъя гэдэг санаа гарч ирээд байгаа нь болохгүй байгаад байгаа байхгүй юу. Яг үнэнийг хэлэхэд. Би тэр доод хэдэн арга

хэмжээг нь дэмжиж байна. Үнэхээрийн дэмжье. Манай Хууль зүйн байнгын хороо дэгийн хуулиар тусгай зохицуулалттай ийм асуудлаа хожигдож асуудал оруулж ирж байгаа юм бол одоо үүнийг нь дэмжье л гэж би бол дэмжье гэж байгаа юм. Тэр зардал тал дээр өсгөх гээд байгаа юмыг нь. Харин гаргаж ирэх гээд байгаа эх үүсвэр талынх нь төсөл арга хэмжээ буруу болчихоод байгаа байхгүй юу энэ чинь. Тэгээд энэ нь эргээд бид нар төсвийн тухай хуульдаа ямар ч хөрөнгө оруулалтын ажил эхэлсэн 3 жилд багтааж хийх тухай ярьцаасан. Тэгэхээр 2026, 2027 оны төсөв дээр 20 тэрбумын ачаалал нэмж байгаа байхгүй юу. Яг энэ чинь өөрөө эргээд л. Үндсэндээ 285 тэрбум төгрөг 2026, 2027 онууд дээр тус тус тавьж байж энэ эхлүүлж байгаа ажил чинь бодит ажил болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар чинь өмнөх он жилүүдэд бол шинэ хөрөнгө оруулалт үндсэндээ 300 тэрбум дотор бараг эргэлдэж явсан улс шүү дээ. Тэгэхээр бүхэл бүтэн улсын 1 жилийн шинэ хөрөнгө оруулалттай тэмцэх хэмжээний төсвийн ачаалал ирэх он жилүүдэд ирчих гээд байна. Тийм учраас уг нь энэ чинь 1/3 хэлбэрээрээ явж байх ёстой арга хэмжээг бид нар арай дутуу тавьчихсан. Тэгсэн хэр нь дахиад тэрнээсээ танаад байхаар 2026, 2027 оны төсвийн хөрөнгө оруулалт дээр ирэх ачаалал буюу шинэ орон зайн асуудал хумигдчихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг л их бодох ёстой юм. Тэгээд уг нь асуулттай бол энэ дээр нь нэг тодорхой асуулт авчихъя. Энэ чинь өөр эх үүсвэр гаргаж ирэх бололцоо байхгүй юм уу гэж.

**Ц.Даваасүрэн:** Энэ тодорхой асуудал маань нөгөө зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр гарсан учраас тэр саналын томъёолол үргэлжлээд, хэлэлцээд явах юм байна. Тэгээд тайлбартай. Тэгэхээр энэ эх үүсвэрийн асуудал чинь Хууль зүйн байнгын хороо дээр хураагдсан санал болчихоод байгаа юм.

Ингээд Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсон 12 гишүүн дэмжиж 75 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай төслийн 2 дахь хэлэлцүүлгийн тодорхой асуудлын хүрээнд дахин явуулсан талаар Байнгын хорооноос бас дүгнэлт гаргах ёстой юм байна. Дүгнэлтийг сайн дураараа танилцуулах гишүүн байна уу. Тэгье. Баясгалан гишүүн танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулсан талаарх хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

14.23 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ